

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй халамжийн бодлогын нөлөөлөл

Эрдэнэбат Баярсайхан^{*1}, Намуунаа Мөнгөн²

^{*1}Эдийн засаг, хөгжлийн яам, Зөвлөх, Улаанбаатар хот, Монгол Улс

²Сангийн яам, Мэргэжилтэн, Улаанбаатар хот, Монгол Улс

*Corresponding author: erdenebat.b51@gmail.com

Received: 28 February 2025 / Accepted: 21 March 2025 / published online: 01 May 2025

Түлхүүр үгс:

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, татварын хөнгөлөлт

©2025 Author(s)



Хураангуй: Энэхүү судалгааны ажлаар Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018, 2021, 2022 онуудын өгөгдөл ашиглан хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсийг хязгаарлагдмал хамааран хувьсагчийн пробит загвар ашиглан судалж, Difference-in-Difference үнэлэгчээр бодлогын нөлөөг тооцохыг зорилго. Үнэлгээний үр дүнд бусад хүчин зүйлсийн нөлөө тогтмол үед эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх магадлал эрэгтэйчүүдийнхээс 12.8 хувиар бага ба хүүхдийн мөнгөн тэтгэмж авдаг эмэгтэйн хөдөлмөр эрхлэлт нь 12.1 хувиар буурдаг байх магадлалтайг тогтоолоо. Иймд халамжийг зорилтот бүлэгт шилжүүлж, хөдөлмөр эрхэлж буй өрхөд гэр бүлийн нөхцөл байдлаас хамаарсан татварын хөнгөлөлт эдлүүлж, тэдний орлогыг өсгөх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжтой байна.

The Impact of Welfare Policies on Women's Employment

Bachelor of Arts in Economics (BA), Erdenebat Bayarsaikhan^{*1}

^{*1}Consultant, Ministry of Economy and Development, Ulaanbaatar, Mongolia

Bachelor of Business Administration in Accounting (BBA), Namuunaa Mungun²

²Specialist, Ministry of Finance, Ulaanbaatar, Mongolia

Key words: Gender, child benefits, women's employment, welfare, tax policy.

Abstract

This study uses microdata from the 2018, 2021, and 2022 surveys of the Household Socio-Economic Study (HSES) to evaluate the factors influencing employment using a limited dependent variable-probit model. It aims to assess the social support and welfare policy impact using a Difference-in-Differences (DID) estimation. The results show that when controlling for other factors, the likelihood of women being employed is 12.8% lower than that of men, and the likelihood of a woman receiving child benefits being employed is 12.1% lower. Therefore, it is possible to shift welfare support to targeted groups and provide tax benefits based on

family circumstances to working households, thereby increasing their income and promoting employment.


I. УДИРТГАЛ

Хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих ёстой гэсэн үзэл санааг дэвшүүлсэн судлаачдын нэг Нобелийн шагналт эдийн засагч Алфред Маршалл 1870-аад онд хийсэн судалгааныхаа үр дүнд тулгуурлан эдийн засгийн хамгийн чухал үүрэг бол материаллаг аж байдлыг сайжруулах явдал бөгөөд үүнд хөдөлмөр эрхлэлт нэн чухал ач холбогдолтой тул ажилгүйдлийг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийг хангалттай хэмжээнд байлгахын тулд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулан хөшүүрэгдэх хэрэгтэй гэжээ. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр эрхлэлт нь хувь хүн, үндэсний түвшинд эерэг нөлөө үзүүлдэг, үнэ цэн бүхий эдийн засгийн үзүүлэлт учир ажилгүйдлийг бууруулахад онцгой анхаарах шаардлагатай юм. Үүнийг А.Маршаллын боловсруулсан дотоод цэвэр үнэ цэний онол хэмээн нэрлэсэн байдаг (Удирдлагын академи, 2020). Онолын гол санаа нь хөдөлмөр эрхлэлт нь микро, макро түвшин дэх харилцан үйлчлэлийн үндсэн дээр тодорхой үнэ цэнийг бий болгодог ба энэ нь хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин, нийт орлого, дотоодын нийт бүтээгдэхүүн зэрэг макро түвшний хувьсагчдаар тодорхойлогдоно. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтын үр дүнтэй байдал нь хувь хүн, үндэсний түвшинд бий болгосон үнэ цэнээр хэмжигддэг (D.Hoffman, 2008). Иймд хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний оролцооны түвшин зэрэг нь эдийн засгийг тэлэх, аж байдлыг сайжруулах чухал эх сурвалж тул тус үзүүлэлтүүдэд онцгойлон анхаарах шаардлагатай.

Монгол Улсын ажиллах хүчний оролцооны түвшин 1992-2023 оны хооронд 75.8 хувиас 59.5 хувь болж буурчээ. Уг бууралтад эмэгтэй ажиллах хүчний оролцооны түвшин 20.8 нэгж хувиар буурсан нь голлох нөлөө үзүүлсэн байна. Улмаар дээрх хугацаанд ажиллах хүчний оролцооны түвшин дэх хүйсийн ялгаа 6.2 нэгж хувиас 16.0 нэгж хувь болтлоо өсжээ.

Зураг 1. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр

(нэгж: хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (ҮСХ)

Дэлхийн Эдийн Засгийн Форумгаас гаргадаг жендерийн зөрүүтэй байдлын тайланд (Global Gender Gap Index Report) дэлхийн дундаж үзүүлэлт 2022 оны байдлаар 68.1 хувь байсан бол Монгол Улс 71.5 хувиар нийт 145 орноос 70 дугаар байранд орж байна. Монгол Улсад жендерийн тэгш байдлыг хангаж, Тогтвортой хөгжлийн зорилт 2030-ын хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхэд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин болон улс төр дэх төлөөлөл хангалтгүй байгаа нь гол саад болж байгааг Жендерийн үндэсний хорооноос гаргадаг Монгол Улс дахь жендерийн тэгш байдлын өнөөгийн түвшин судалгаанд дурджээ (Жендерийн үндэсний хороо, 2022). 2023 оны байдлаар Монгол Улсын нийт 3.5 сая хүн амын 51 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд насны ангиллаар авч үзвэл нийт эмэгтэйчүүдийн 60 орчим хувийг хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд бүрдүүлж байна.

Зураг 2. Хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2023 он

(нэгж: мянган хүн)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хэдийгээр хүн амын бүтэц хүйсийн хувьд харьцангуй тэнцвэртэй боловч эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс мэдэгдэхүйц бага байна. Иймд дээрх зөрүү, ялгааг үүсгэж буй учир шалтгааныг тогтоох, түүнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зураг 3. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2023 он

(нэгж: хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Манай улсын хувьд эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү өндөр байдаг ч эмэгтэйчүүд гэр бүлийн шинжтэй үүрэг, хариуцлагыг илүүтэй хүлээдэг тул эзэмшсэн боловсролоо ашиглаж, хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох боломжоор дутмаг байна (Удирдлагын академи, 2020).

Эмэгтэйчүүдийн ажиллах хүч дэх оролцоог нэмэгдүүлснээр дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх боломжтой болохыг судалгаагаар баталсан байдаг (McKinsey Global Institute, 2018). Тухайлбал, өрх гэр болон ажлын байран дахь жендерийн тэгш бус байдлыг арилгаснаар Монгол Улс эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшнийг 63.2 хувь хүртэл өсгөх боломжтой гэж Азийн Хөгжлийн Банк (АХБ) тооцоолсон байна. Ингэснээр нэг хүнд ногдох ДНБ-ий жилийн өсөлтийн түвшнийг 0.5 хувиар нэмэгдүүлж, 30 жилийн дотор дотоодын нийт бүтээгдэхүүнийг 16.1 хувиар өсгөх боломжтой (Азийн хөгжлийн банк, 2020) гэсэн дүгнэлтэд хүрчээ.


Иймд ажиллах хүч дэх эмэгтэйчүүдийн оролцоо нь аливаа улсын нийгмийн болон хөгжлийн чухал зорилт төдийгүй эдийн засгийн өсөлтийн томоохон хүчин зүйл тул эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой бодлогын судалгаа зайлшгүй шаардлагатай байгааг сүүлийн жилүүдийн статистик мэдээллээс харж болохоор байна. Түүнчлэн манай улсад хийгдсэн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгаанд ихэвчлэн эмэгтэйчүүдийн нас, боловсрол, орлого зэргийн нөлөөг судалсан байгаа бол эмэгтэйчүүдийн өрхийн статус, хүүхдийн тоо, тэдгээрт олгогдож буй халамжийн бодлогын нөлөөг судалсан судалгаа цөөхөн байна.

II. МОНГОЛ УЛС ДАХЬ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БОДЛОГО

Монгол Улсын хувьд нийгмийн зүгээс зайлшгүй дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдэд төрөөс халамж үзүүлэх зорилгоор Нийгмийн халамжийн анхны бие даасан хуулийг УИХ-аас 1995 онд баталж, хэрэгжүүлж ирсэн. Монгол Улсын хувьд нийгмийн халамжтай холбоотой Нийгмийн халамжийн тухай хууль (2012), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай (2016), Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай (2017), Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай (2011), Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай (2017), Ахмад настны тухай (2017) хуулиуд болон дагалдах дүрэм, журмууд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын нийгмийн халамжийн хүрээнд үндсэн 12 бүлгийн 72 төрлийн үйлчилгээг хэрэгжүүлдэг. 2022 оны байдлаар давхардсан тоогоор 2.6 сая иргэн, 2 их наяд төгрөгийн халамж авсан байна. “Дэлхийн нийгмийн хамгааллын тайлан 2020-2022”-д дэлхийн нийт хүн амын 46.9 хувь нь ямар нэгэн байдлаар нийгмийн хамгааллын тэтгэмж авч байсан, мөн ДНБ-д эзлэх нийгмийн хамгааллын зардлын хувь 12.9 хувь байгааг онцолжээ. Тус тайланд Монгол Улс нь ижил түвшний орлоготой улс орнууд болон бүс нутгийн улсуудаас харьцангуй өндөр халамжийн зардалтай байгааг тусгасан байна (Нээлтэй нийгэм форум, 2023).

Зураг 4. Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон, тэтгэмж, үйлчилгээний хэмжээ, төрлөөр
(нэгж: зүүн тэнхлэг: сая төгрөг, баруун тэнхлэг: хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 2018 онд 622.95 тэрбум төгрөг, 2019 онд 670.80 тэрбум төгрөг байсан бол 2020 онд хүүхдийн мөнгөн тэтгэмж 5 дахин өссөнтэй холбоотойгоор 1.59 их наяд болж өмнөх оноос 137 хувиар нэмэгдсэн байна. 2023 оны байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 2.12 их наяд төгрөг олгосон байгаагийн 71.5 хувь буюу 1.52 их наяд төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид олгосон байна.

Түүнчлэн эмэгтэйчүүдэд чиглэсэн дараах төрлийн нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээ нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд сөргөөр нөлөөлөх магадлалтай байна.

Хүснэгт 1. Эмэгтэйчүүдэд чиглэсэн халамж, хөгжлийн үйлчилгээний төрөл, хэмжээ, 2023 он

(нэгж : мянган хүн; тэрбум төгрөг)


№	Нийгмийн халамжийн төрлүүд	Давтамж	Мөнгөн дүн	Халамж хүртэгч	Хамрагдсан иргэдийн тоо	Зардал
1	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	Сар бүр	100,000	Хүүхэд	1,305.3	1,520.1
2	Ихэр хүүхдийн тэтгэмж	Нэг удаа	ихэр тутамд 1,000,000, 3 ихэр тутамд 3,000,000	Хүүхэд	0.7	1.5
3	Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	Сар бүр	1-2 хүүхэд бол 375,000, 3-4 хүүхэд бол 562.500, 5	Хүүхэд	16.5	57.8

			болон түүнээс дээш хүүхдэд 750,000			
4	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны	Сар бүр	375,000	Хүүхэд	n/a	n/a
5	"Эхийн алдар" одонтой эхэд	Жил тутам	2 дугаар одонтой бол 100,000, 1 дүгээр одонтой бол 200,000	Эх	252.7	31.5
6	Жирэмсэн эхийн тэтгэмж	Сар бүр	40,000	Эх	73.8	10.1
7	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	Сар бүр	50,000	Эх	184.8	77.9
8	Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	Улирал тутам	660,000	Ганц бие эцэг, эх	8.5	16.3
9	18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг	Сар бүр	375,000	Ганц бие эцэг, эх	0.0	0.0
10	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх	Нэг удаа	1,200,000	Ганц бие эцэг, эх	n/a	n/a
11	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа	Сар бүр	375,000	Асран хамгаалагч	2.1	4.8
12	Хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг асран хамгаалж буй хүнд	Сар бүр	375,000	Асран хамгаалагч	0.2	0.5
13	Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа	Сар бүр	375,000	Асран хамгаалагч	0.2	0.3
14	Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа	Сар бүр	375,000	Асран хамгаалагч	67.5	119.6
Нийт					1,912.3	1,840.5

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Холбогдох судалгааны үр дүнд халамж авдаг иргэд халамж авдаггүй иргэдтэй харьцуулахад хөдөлмөр эрхлэлт 12.13 хувиар бага байх магадлалтай байна (Нээлтэй нийгэм форум, 2023). Мөн судалгаанд өндөр орлоготой өрхийн гишүүдийн хувьд 3.98 хувиар хөдөлмөр эрхлэлтийг бууруулж байгаа бол бага орлоготой өрхүүдийн хувьд халамж авах нь хөдөлмөр эрхлэлтийг 15.64 хувиар бууруулах магадлалтайг дурджээ. Түүнчлэн хүүхдийн мөнгөн тэтгэмж нэмэгдсэнээр нийт хүн амын хөдөлмөр эрхлэлтийг 4.83 хувиар мөн бууруулж байна.

Зураг 5. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэхээс өмнөх ба дараах эмэгтэйчүүдийн ажиллах оролцооны түвшин (нэгж: хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улс бодлогын түвшинд халамжаас хөдөлмөрт зарчмыг хэрэгжүүлэхээр тунхаглаж байгаа ч нийгмийн халамжийн зорилтот бүлгийг тодорхойлж буй аргачлал оновчгүй байгаа явдал нь хамрах хүрээ өргөжих явдлыг нөхцөлдүүлж, халамжаас хөдөлмөрт зарчим бодит байдал дээр биелэх боломжгүй нөхцөл байдал үүсжээ (Удирдлагын академи, 2020). Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог судалж, зөв бодлогын арга хэрэгсэл ашиглан тэдний хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх нь охид, бүсгүйчүүдийг гэр бүл, нийгэм, эдийн засгийн хувьд илүү үнэ цэнтэй болгодог.

III. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн сеграгаци үүсэж буй шалтгаан нөхцөлийг тайлбарлахдаа эдийн засгийн хүчин зүйлстэй холбон тайлбарладаг хоёр гол онол байдаг байна. Үүнд Минсер, Полачек нарын “Хүний капитал”-ын онол Беккер нарын “Рационал сонголт”-ын онол багтана.

“Хүний капитал”-ын онолд мэргэшсэн байдал буюу хөдөлмөрийн зах зээлд эрэлт сайтай байх, ажлын туршлага гэсэн хоёр элементийг багтаан авч үздэг ба эмэгтэй хүн гэр бүлийн хөдөлмөрт эрэгтэйчүүдээс илүүтэй анхаарал тавих, ялангуяа, хүүхэд төрүүлдэг нь түүний хүний капиталын хөгжилд, өөрөөр хэлбэл, мэргэжлийн хөгжил, туршлага хуримтлуулах байдалд нь сөргөөр нөлөөлдөг тул эмэгтэйчүүд нь мэргэжлийн ур чадвар, мэргэшсэн байдал, ажлын туршлага гэсэн үзүүлэлтүүдээрээ эрэгтэйчүүдээс доогуур байна. Үүнтэй уялдан эмэгтэйчүүд нь ур чадвар арай бага шаардах ажлыг сонгон, хүүхэд төрүүлсний дараагаар буцаж ажилдаа орох үед цалин багатай ажилд очиж байна гэж тэд тайлбарладаг.

Харин “Рационал сонголт”-ын онолд хүмүүс өөрсдийн хэрэгцээ, ашиг сонирхлыг хамгийн сайнаар, илүү хангах зүйлийг сонгодог гэж үздэг ба ээж байх уу, эсхүл ажилтан байх уу гэсэн сонголтыг эдийн засгийн хувьд тухайн гэр бүлд аль нь илүү ашигтай гэдгээс

хамааруулан сонголт хийгддэг хэмээн үздэг бөгөөд ажиллаж олсон цалин, ашиг ба гэрийн хөдөлмөрт буюу бусдаар хүүхдээ асруулахад шаардагдах зардлын аль байна гэдгээс хамааруулан рационал сонголтыг хийдэг утгаар эрэгтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн ялгааг тайлбарладаг байна. (С.Түмэндэлгэр, 2004)

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөг (Khishigt Dandarchuluun, 2019) судалж, ҮСХ-ны Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Түүвэр судалгааны панел өгөгдлийг ашиглан МУ-д хүүхдийн мөнгөн тэтгэмж олгож эхлэхээс өмнөх үе (2002-2003) ба дараах үе (2007-2008)-үүдийг харьцуулахад хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин халамжаас шалтгаалан 12.3 нэгж хувиар буурсныг илрүүлсэн байна. Мөн хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ажилласан цаг жилийн туршид 155.3 цагаар буурсан болохыг тооцоолжээ.

Түүнчлэн Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Нэгдсэн Үндэсний Байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын томоохон байгууллагууд холбогдох судалгаанууд хийсэн байна. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны “Ажиллах хүч дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог ижил түвшинд хүргэснээр Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих нь” судалгаанд ажиллах хүч дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөр эрхэлж буй гэр бүлийг дэмжсэн татварын хөнгөлөлтийн бодлого нэвтрүүлэх зохицуулалтыг зөвлөсөн байна.

Хүснэгт 2. Судлагдсан байдлын хураангуй

Судлаач	Судалгааны сэдэв	Тоон өгөгдөл ба Аргачлал	Үр дүн
Г.Цэвээндолгор, (МА) Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Нийгмийн Ухааны салбар, эдийн засгийн тэнхимийн цагийн багш	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд асран халамжлах ажлын үзүүлэх нөлөөг хэмжих нь	Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос гаргадаг “Цаг ашиглалтын (ЦАС)”-ны 2019 оны тоон мэдээллийн нийт түүврээс 15-64 насны 4,290 эмэгтэйн мэдээллийг ялган авч хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн судалгааны ажлуудад ихэвчлэн ашигладаг пробит загвараар үнэлгээгээ хийсэн байна. (Г.Цэвээндолгор, 2022)	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх магадлалд нас, бакалаврын боловсрол, гэрлэсэн болон салсан, нэг болон хоёр хүүхэдтэйгээ хамт амьдардаг байх нь эерэг нөлөө үзүүлдэг бол хотод амьдардаг байх, өрхийн ам бүлийн тоо, хүүхэд асрахад зарцуулж буй цаг, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүн асрахад зарцуулж буй цаг, 0-2 насны хүүхэдтэй байх зэрэг нь сөрөг нөлөө үзүүлдэг. Эмэгтэйчүүдийн хүүхэд асрах цаг нэгээр нэмэгдэхэд ажиллах хүчинд оролцох магадлал нь 6.2 хувиар, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах цаг нэгээр нэмэгдэхэд 7.0 хувиар буурдаг байна. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд 0-2 насны хүүхэдтэй бол хөдөлмөр эрхлэх магадлал нь

			үүнээс дээш насны хүүхэдтэй эмэгтэйчүүдтэй харьцуулахад 6.5 хувиар бага байдаг гэж үнэлэгджээ.
Khishigt ба Hyung Jai	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн нийлүүлэлт дэх хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нөлөө	Хүүхдийн тэтгэмжийн хөтөлбөрийн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд үзүүлэх нөлөөг хүүхдийн тэтгэмжийн хөтөлбөрт хамрагдсан эмэгтэйчүүд болон хөтөлбөрт хамрагдаагүй эмэгтэйчүүдийн бүлгийг харьцуулах замаар Difference-In-Differences аргыг ашиглан судалжээ	Энэ судалгаа нь 2002/2003 оны өрхийн орлого, зарлагын нэгдсэн судалгаа, 2007/2008 оны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны тоон мэдээллийг ашигласан ба хүүхдийн мөнгөн тэтгэмж (бэлэн мөнгөний шилжүүлэг) нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог 12.27 хувиар бууруулдаг гэдгийг олж тогтоосон. Үүнийгээ ажилласан цагийн регрессийн үр дүнгээр ахин нотолсон байна. (Khishigt Dandarchuluun, 2019)
Б.Даваамаа Монгол Улсын их сургууль	Залуу эмэгтэй төгсөгчдийн ажиллах хүчний оролцоо	Залуу төгсөгчид, ялангуяа залуу эмэгтэй төгсөгчдийн ажиллах хүчний оролцоог шугаман регресс болон пробит загвар ашиглан судалсан байна. (Б.Даваамаа, 2020)	Энэхүү судалгааг хөдөлмөрийн бүтээмж өндөртэй залуус буюу 15-35 насны Мэргэжил боловсрол, сургалтын байгууллага (МБСБ), Их, дээд сургууль (ИДС) төгсөгчдийн Хөдөлмөр эрхлэлтийн судалгааны (2014-2016) тоон мэдээлэлд үндэслэн хийсэн байна. Эмпирик судалгааны үр дүнгээс харахад залуу эмэгтэйчүүдийн ажиллах хүчинд оролцох магадлал нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад 11.2 хувиар бага байдаг ба залуу эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд гэрлэлт, боловсролын түвшин, сургалтад хамрагдах болон өмнөх жил хөдөлмөр эрхэлсэн байх нь чухал нөлөө үзүүлдэг. Харин өрхийн ам бүлийн тоо, хөдөө амьдардаг байх нь нөлөөгүй буюу статистикийн хувьд ач холбогдолгүй байна
Б.Дуламзаяа Монголбанк, Судалгаа, Статистикийн газар, Судалгааны хэлтэс, Захирал.	Ковид-19 цар тахлын хөдөлмөрийн зах зээлд үзүүлсэн нөлөө: Монгол Улсын жишээ	Судалгаанд Монгол Улсын ажиллах хүчний судалгааны 2017-2021 оны микро тоон өгөгдлийг ашиглан, шугаман регрессийн аргаар үнэлгээг хийсэн	Цар тахлаас шалтгаалан эмэгтэй, бага, дунд боловсролтой, нийслэл хотод ажил эрхэлдэг ажиллагсдын ажлын цаг болон хөдөлмөрийн орлого илүүтэйгээр буурч, тэгш бус байдал нэмэгджээ. Түүнчлэн, цар тахлын улмаас хувийн секторт

бөгөөд үүний үр дүнд цар тахал нь тухайн ажилчны хувь хүний шинж чанараас хамааран харилцан адилгүй нөлөөлж, ажлын цаг болон хөдөлмөрийн орлогыг бууруулсан болохыг тогтоосон байна.

ажиллагсдын ажлын цаг мэдэгдэхүйц буурсан бол төрийн секторт уг нөлөө төдийлөн ажиглагдаагүй байна. Хөдөлмөрийн орлогын хувьд бизнесийн орлоготой ажиллагсад цалингийн орлоготой ажиллагсдаас илүү цар тахалд өртжээ. (Б.Дуламзаяа, 2022)

С.Мөнхчимэг Монголбанкны ССГ-ын ТСШ-ний албаны эдийн засагч	Нийгмийн халамжийн хөдөлмөрийн зах зээл, ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөө	Судалгааг 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн талаарх боломжит тоон мэдээлэл, төсвийн халамжийн сангийн зарцуулалт зэргийг ашиглан хөдөлмөрийн зах зээл дэх халамжийн нөлөөг олон хувьсагчтай энгийн регрессийн загварыг ашиглан тооцсон байна. (С.Мөнхчимэг, 2018)	Халамжийн нийт зардал нэмэгдсэн нь ажиллах хүчний оролцооны түвшин, ажил эрхлэлт, бодит дундаж цалин, ажилгүйдэл зэрэгт нөлөөгүй болох нь тогтоогдсон байна. Харин зөвхөн хувиараа аж ахуй эрхлэх хандлагыг бага зэрэг бууруулах нөлөөтэй байна. Уг үр дүн тоон мэдээллийн олдоц, чанар, эконометрик загварын сонголтын тодорхой бус байдлаас ихээхэн шалтгаалж байгаа ба цаашид нийгмийн халамжийн хөтөлбөр бүрийн хувьд микро түвшний тоон мэдээллийг бүрдүүлж, халамжийн хөтөлбөр бүрийн хувьд хөдөлмөрийн зах болон эдийн засаг дахь нөлөөг нарийвчлан үнэлэх нь зүйтэй гэжээ.
Санхүүгийн хүртээмж, хөгжил санаачилга ТББ	Цалин болон халамжийн бодлого иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөөллийн судалгаа	Судалгаанд 2017, 2019 болон 2021 онуудад хийгдсэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны хөдөлмөрийн насны хүн амын мэдээлэлд тулгуурлан “логистик” болон “пробит” загварыг үнэлэн, хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй цалин, халамжийн бодлогын нөлөөг регрессийн шинжилгээний аргыг ашиглан тодорхойлсон байна.	Нийт хүн амын хөдөлмөр эрхлэлтийн нас нэгээр нэмэгдэх, хүйсийн хувьд эрэгтэй байх, 5-аас доош насны хүүхэдтэй байх нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж байна. Мөн цалингийн хэмжээ өсөх нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж байгаа бол халамж авах болон хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн нь хөдөлмөр эрхлэлтийг бууруулж байна. Халамжийн хэмжээг нэмэгдүүлэх нь бага орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг багасгаснаар, ядуурлын түвшнийг бууруулж, дундаж давхаргыг нэмэгдүүлэхэд саад учруулж байх магадлалтай байна гэжээ. (Нээлтэй нийгэм форум, 2023)

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

IV. ӨГӨГДӨЛ

Энэхүү судалгаанд Үндэсний Статистикийн хорооны ӨНЭЗС-ны 2018, 2021, 2022 онуудын зэрэгцүүлсэн өгөгдлийг нийлүүлэн, 18-60 хүртэлх насны нийт 90'001 иргэний нэгтгэн зэрэгцүүлсэн (Pooled-Cross section) өгөгдлийг ашиглан тооцооллыг хийв. Тооцооллыг Eviews-12 программ ашиглан гүйцэтгэлээ. Тооцооллыг хийхдээ онолын талаас болон судлаачдын зүгээс хөдөлмөр эрхлэлтэд нөлөө бүхий 40 орчим (боловсруулсан болон гарган авсан) хувьсагчдыг ашиглав. Үүнд боловсрол, нас, хүйс, өрхийн ам бүлийн тоо, хүүхдийн тоо, тэтгэвэр тэтгэмжийн орлого, халамжийн орлого, цалингийн орлого, гэрлэлтийн байдал, он болон бусад хувьсагчид багтана.

Хүснэгт 3. Хувьсагчдын хураангуй статистик үзүүлэлт

Хувьсагч	Ажигл алтын утга	Дунд аж	Ст.ха зайлт	Бага утга	Их утга	Ажигл алтын утга	Дунда ж	Ст.ха зайлт	Бага утга	Их утга	Ажигл алтын утга	Дунда ж	Ст.ха зайлт	Бага утга	Их утга
	2018					2021					2022				
нас	29723	37.6	11.3	19	59	20009	38.05	11.2	19	59	40269	38.63	11.8	18	60
нас_15_25*	29723	0.17	0.1	0	1	20009	0.17	0.4	0	1	40269	0.17	0.37	0	1
нас_25_35*	29723	0.3	0.5	0	1	20009	0.27	0.45	0	1	40269	0.26	0.44	0	1
нас_35_45*	29723	0.25	0.4	0	1	20009	0.27	0.44	0	1	40269	0.26	0.44	0	1
нас_45_60*	29723	0.28	0.4	0	1	20009	0.29	0.45	0	1	40269	0.31	0.46	0	1
5 хүртэлх насны хүүхдийн тоо	29723	0.11	0.3	0	2	20009	0.09	0.3	0	2	40269	0.09	0.29	0	2
хүүхдийн мөнгө*	29723	0.69	0.5	0	1	20009	0.73	0.44	0	1	40269	0.72	0.45	0	1
нийгмийн даатгалын мөнгө*	29723	0.34	0.5	0	1	20009	0.32	0.47	0	1	40269	0.35	0.48	0	1
халамжийн мөнгө*	29723	0.84	0.4	0	1	20009	0.96	0.2	0	1	40269	0.87	0.33	0	1
боловсрол (жилээр) хөдөлмөр эрхлэлт (сүүлийн 7 хоног)*	29723	11.6	3.8	0	21	20009	11.52	4.0	0	21	40269	11.49	4.10	0	21
эмэгтэй*	29723	0.53	0.50	0	1	20009	0.52	0.50	0	1	40269	0.52	0.5	0	1

эрүүл мэнд(сүүлийн 12 сард эмнэлэгт хэвтсэн эсэх)* гэр бүлийн хэмжээ	29723	0.12	0.32	0	1	20009	0.11	0.31	0	1	40269	0.14	0.35	0	1
	29723	4.22	1.68	1	16	20009	4.21	1.64	1	13	40269	4.16	1.66	1	17
хөдөлмөрийн н дэмжлэг*	29723	2	0.049	1	2	20009	2	0.03	1	2	40269	2	0.05	1	2
хөдөлмөрийн н сургалт*	29723	0	0.03	0	1	20009	0	0.02	0	1	40269	0	0.02	0	1
гэрлэлтийн байдал*	29723	0.7	0.46	0	1	20009	0.7	0.46	0	1	40269	0.7	0.46	0	1
сүүлийн 12 сарын нийт цалингийн орлого, сая	29723	6.78	7.59	-	166	20009	8.4	10.8	-	180	40269	10.3	12.4	-	260
нийт_хүүх дийн тоо	29723	1.58	1.23	0	8	20009	1.65	1.23	0	7	40269	1.64	1.27	0	8
нийт_орлог о, сая ₮	29723	10.4	8.34	0.04	166	20009	16.7	12	0.05	184	40269	19.1	13.4	0.03	265
нийт_НД орлого, сая ₮	29723	1.48	2.69	-	50.9	20009	1.82	3.18	-	30	40269	2.34	3.94	-	57.3
нийт_хала мжийн_орл ого, сая ₮	29723	0.75	0.96	-	9.8	20009	3.2	2.39	-	17.2	40269	2.71	2.24	-	18.4
нийт_тэтг эвэр, сая ₮	29723	1.07	2.34	-	23.5	20009	1.45	2.99	-	30	40269	1.88	3.64	-	36
нийт_хүүх дийн_мөнгө , сая ₮	29723	0.31	0.302	-	2.04	20009	1.8	1.54	-	9.2	40269	1.88	1.63	-	14.4
хот*	29723	0.44	0.450	0	1	20009	0.44	0.497	0	1	40269	0.46	0.498	0	1
он*	29723	2018	0	2018	2018	20009	2021	0	2021	2021	40269	2022	0	2022	2022

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол


Тайлбар: 1) * тэмдэглэгээ нь 1 эсвэл 0 гэсэн утга авах дамми хувьсагчийг илэрхийлнэ. 2) Он тус бүрээр хураангуй статистикийг харуулав.

Статистик үзүүлэлтээс харвал судалгаанд ашигласан түүврийн 52.4 хувь нь эмэгтэй, нийт түүврийн дундаж нас 38.1, дундаж суралцсан жил 11.5 байсан бол түүврийн 62.5 хувь нь сүүлийн 7 хоногт ажил хийсэн байна. Хүйсээр нь ангилан үзвэл, нийт эмэгтэйчүүдийн 56.5 хувь нь сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлсэн байгаа бол нийт эрэгтэйчүүдийн 69.0 хувь нь мөн үед хөдөлмөр эрхэлжээ. Түүнчлэн түүвэрт хамрагдсан өрхүүдийн гишүүдийн

дундаж тоо 4.2 хүн байгаа ба нийт өрхийн 84 хувь нь нийгмийн халамжийн сангаас ямар нэг төрлийн халамж болон тэтгэмж авсан байна.

Хөдөө аж ахуй болон газар тариалан эрхлэн аж төрдөг өрхүүдийн хувьд тэтгэмж, халамжийн бодлогоос үл хамааран хөдөлмөрийн хуваарь нь өөрчлөгдөхгүйгээр өрхийн хөдөлмөр эрхлэх хандлагатай тул хөдөө аж ахуй болон газар тариалан эрхлэн амьдардаг өрхүүдийн мэдээллийг оруулалгүй үнэлгээ хийх нь оновчтой гэж үзлээ.

Зураг 6. Хүйс тус бүрийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: Дугуйн хэмжээ нь хүйс тус бүрийн ажил эрхэлж буй хувийг илтгэнэ.

Хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн нийт эмэгтэйчүүдэд эзлэх хувь нь он тус бүрийн хувьд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнээс бага байна. Түүврийн хөдөлмөр эрхлэлтийн түвшний зөрүү 2018 онд 12.5 хувь байсан бол 2021 онд 13.6 хувь болон өссөн байна. Энэ нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан эдийн засгийн уналт, ажлын байрны хомсдол болон тухайн үед хэрэгжиж байсан халамж, тэтгэмжийн бодлогоос шалтгаалан өссөн байх боломжтой. Эмэгтэйчүүдийн хувьд хөдөлмөр эрхлэлтэд хамгийн хүчтэй нөлөөлж буй хүчин зүйлсийг эконометрик загвараар үнэлэхийг зорилоо.

Ү. АРГА ЗҮЙ

Сүүлийн жилүүдэд зэрэгцүүлсэн (Cross-Section) өгөгдлүүдийг нийлүүлэн эмпирик судалгаанд ашиглах нь улам бүр нэмэгдэж байна. Ялангуяа бодлогын үр нөлөөг үнэлэхэд тус холимог буюу нэгтгэн зэрэгцүүлсэн (Pooled cross-section) өгөгдлийг ашиглан, ялгаврын нөлөө (Difference in difference)-г ашиглаж байна. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн микро судалгаа хийхэд хязгаарлагдмал хамааран хувьсагчийн пробит, логистик загварууд түгээмэл хэрэглэгдэж байна.

Энэхүү судалгаанд ӨНЭЗС-ны 2018, 2021, 2022 оны холимог буюу нэгтгэн зэрэгцүүлсэн өгөгдлөөр хязгаарлагдмал хамааран хувьсагчийн загвар үнэлэв. 2020 онд хүүхдийн мөнгийг 100'000 төгрөг болгон нэмэгдүүлсэн болон бусад халамжийн бодлогын

үр нөлөөг хугацааны үеүдэд тооцох үүднээс ялгаврын нөлөөний шинжилгээ (difference in difference analysis) ашиглан тооцооллыг хийлээ.

5.1. Эконометрик загварчлал

Хязгаарлагдмал хамааран хувьсагчийн загвар

Утгуудын хувьд хязгаарлагдмал утга авдаг хувьсагчийг (тухайлбал 0 болон 1 гэсэн утга авах) бусад хүчин зүйлсээс хамаатуулан үнэлэхэд тархалтаас нь хамааран тобит, пробит, логистик загваруудыг ашигладаг. Хязгаарлагдмал хамааран хувьсагчтай загвар нь шугаман бус загвар тул ердийн үнэлэгчээр үнэлэх боломжгүй юм. Иймд хамгийн их магадлалын үнэлэгчийг ашиглах нь зүйтэй. Хуурмаг хамааран хувьсагч бүхий загварын хязгаарлагдмал утга авах магадлалыг тооцоход стандарт нормал тархалтын $0 < G(z) < 1$ тохиолдол биелэх $G(\beta_0 + x\beta)$ функцээр загварчлах шаардлагатай. Үүний нэг хувилбар нь стандарт нормал өсөн нэмэгдэх тархалтын функц буюу пробит загвар юм. Пробит загварыг дараах байдлаар загварчилна.

$$\phi(z) = \left(\frac{1}{\sqrt{2\pi}} \right) * e \left(- \left(\frac{z^2}{2} \right) \right)$$

Стандарт нормал тархалтын өөр нэгэн хэлбэр нь стандарт логистик санамсаргүй хувьсагчийн өсөн нэмэгдэх тархалтын функц юм. Үүнийг дараах байдлаар томъёолдог.

$$G(z) = \frac{e(z)}{[1 + e(z)]} = \Lambda(z)$$

Дээрх загварчлалыг ашиглан эконометрик тэгшитгэлээр бичвэл:

$$\begin{aligned} P(\text{Хөдөлмөр эрхлэлт}_{it} = 1) \\ = \phi(\alpha + \beta Z_{it} + \beta_2 y_{2021} + \beta_2 y_{2022} + \rho_1 \text{халамж}_i + \rho_2 \text{эмэгтэй}_i \\ + \rho_3 \text{эмэгтэй}_i * \text{халамж}_i + \delta_1 y_{2021} * (\text{эмэгтэй}_i * \text{халамж}_i) + \delta_2 y_{2022} \\ * (\text{эмэгтэй}_i * \text{халамж}_i) \end{aligned} \quad (1)$$

Энд *Хөдөлмөр эрхлэлт* нь 1, 0 гэсэн утга авдаг хуурмаг хувьсагч, Z_{it} нь вектор хувьсагч ба хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөх бусад хүчин зүйлийг хянасан хувьсагчид багтана. Үүнд нас, насны квадрат, гэр бүлийн гишүүдийн тоо, эрүүл мэндийн нөхцөл байдал, боловсролын түвшин, хүүхдийн тоо, 5 хүртэлх насны хүүхэдтэй эсэх, гэрлэлтийн байдал, болон “хүйс, халамж, он”-уудыг хамарсан харилцан үйлчлэлийн хувьсагчид (interaction variable) багтана. y_{2021} , y_{2022} нь онуудыг илтгэсэн дамми хувьсагч ба 2018 оныг суурь дамми болгон тэгшитгэлд тусгав. халамж_i нь i дугаар гишүүн халамж авдаг бол 1 бусад бол 0 гэсэн утга авах дамми хувьсагч, эмэгтэй_i нь i дугаар гишүүний хүйсийг илэрхийлэх эмэгтэй бол 1 гэсэн утга авах дамми хувьсагч, $y_{2021} * (\text{эмэгтэй}_i * \text{халамж}_i)$ нь халамж авдаг эмэгтэй бол 1 гэсэн утга авах 2021 оны interaction хувьсагч, $y_{2021} * (\text{эмэгтэй}_i * \text{халамж}_i)$ нь халамж авдаг эмэгтэй бол 1 гэсэн утга авах 2022 оны interaction хувьсагч юм. δ_1, δ_2 нь хүүхдийн мөнгө болон халамжийн мөнгө нэмэгдүүлсэн бодлогын нөлөөг тооцох параметрууд ба сөрөг утга гарах таамаглалыг судлаачдын зүгээс дэвшүүлээ.

5.2. Difference in Difference үнэлэгч

Нэгтгэн зэрэгцүүлсэн өгөгдөл нь ямар нэг бодлого, үйл явдлаас өмнөх болон дараах хугацаа хоорондын нөлөөллийг тооцоолох боломжийг олгодог учир бодлогын үр нөлөөг үнэлэхэд ихээхэн ашиглагддаг арга зүй юм. 2018 онд 604.9 тэрбум төгрөг байсан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал 2021 онд 1.9 их наяд төгрөг болж өссөн нь хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлсөн болохыг энэ судалгаанд DID үнэлгээ ашиглан тогтоов. DID үнэлэгчийг томъёолбол:

$$\hat{\delta} = (Y_{treatment,t+1} - Y_{control,t+1}) - (Y_{treatment,t} - Y_{control,t})$$

Энд treatment нь бодлогын нөлөөнд хамрагдсан иргэдийг ойлгох бол control нь бодлогын нөлөөнд хамрагдаагүй иргэдийг ойлгоно. Бидний хувьд халамж авдаг, эмэгтэй бол treatment group, бусад бол control group юм. t үеийн халамж авдаг өрхийн эмэгтэй гишүүний бусад хүмүүстэй харьцуулахад хөдөлмөр эрхлэх магадлалын ялгааг $t+1$ үеийн ялгаанаас хасахад үе хоорондын халамж авдаг эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн ялгаатай байдлын өөрчлөлтийг гарган авна. Үүнийг харилцан үйлчлэлийн хувьсагчид болгон дараах байдлаар тэгшитгэлдээ оруулж болно.

$$Y_{it} = \beta_0 + \beta_1 \text{Халамж}_i + \beta_2 \text{Эмэгтэй}_t + \beta_3 (\text{Эмэгтэй}_t * \text{Халамж}_i) + \beta_4 \text{Он} + \delta_1 Y_{2021} * (\text{Эмэгтэй}_t * \text{Халамж}_i) + \dots + \epsilon_{it} \quad (2)$$

ҮІ. ҮР ДҮН

Хүйс, халамж, он тус бүрээр ялгаатай хязгаарлагдмал хамааран хувьсагч бүхий олон хүчин зүйлсийн регрессийн загваруудыг пробит, логистик загваруудаар үнэлэн pseudo R^2 , Akaike Information Criterion-ын хувьд хамгийн үр ашигтай үнэлэгчийг сонгон хүснэгт 4-д харуулав.

Үнэлгээний үр дүнд бусад хүчин зүйлсийн нөлөө тогтмол үед эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт эрэгтэйчүүдийнхээс 12.8 хувиар бага байх хандлагатай байна. Энэ нь Б.Даваамаа (2020)-ын ажилтай ойролцоо байгаа бол Нээлттэй нийгэм форум (2023)-ын судалгааны үр дүнгээс өндөр байна. Харин хүүхдийн мөнгөн тэтгэмж авдаг эмэгтэй бусад хүмүүстэй харьцуулахад хөдөлмөр эрхлэх магадлал нь 12.1 хувиар бага байгаа нь Д.Хишигт (2019) судлаачийн судалгааны үр дүн (12.7%)-тай нийцтэй байна. Түүнчлэн судалгааны үр дүнд гэр бүлийн гишүүдийн тоо олон байх, эмэгтэй байх, суралцсан жил нэмэгдэх, халамж, нийгмийн даатгалын тэтгэмж авдаг байх, хүүхдийн мөнгө авдаг өрхийн эмэгтэй байх, сүүлийн 12 сард эмнэлэгт эмчлүүлсэн байх зэрэг нь хөдөлмөр эрхлэлтийг бууруулахаар байна. Харин эсрэгээрээ цалингийн орлого нэмэгдэх, хүүхдийн тоо өсөх, гэрлэсэн байх нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлдэг гэсэн үр дүнд хүрлээ.

Бидний сонирхож буй гол нөлөө болох халамжийн зардал 2020 онд огцом нэмэгдсэн нь ямар нэг төрлийн халамж хүртдэг эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулсан уу гэдэг талаар тодруулъя.

2021, 2022 онуудад ямар нэг төрлийн халамж авдаг байсан эмэгтэй 2018 оны адил төрлийн хүнтэй харьцуулахад хөдөлмөр эрхлэлт харилцан 2.5, 1.8 хувиар бага байгаа хэдий ч 10 хувийн түвшинд статистикийн ач холбогдолгүй байна.

Хүснэгт 4. DID пробит загварын үр дүн

Хувьсагчид	Хөдөлмөр эрхлэлт (хамааран хувьсагч)		
<i>age</i>	0.143***	<i>q_40</i>	-0.0257
	-0.00338		-0.0277
<i>agesq</i>	-0.00175***	<i>q_60</i>	-0.118***
	-4.31E-05		-0.0277
<i>hhsizе</i>	-0.0619***	<i>q_80</i>	-0.0234
	-0.00516		-0.0279
<i>health</i>	-0.246***	<i>y2021</i>	0.164***
	-0.0145		-0.0264
<i>education</i>	-0.0273***	<i>y2022</i>	0.188***
	-0.00132		-0.0241
<i>female</i>	-0.128***	<i>child5_femal</i>	0.0058
	-0.0198	<i>e</i>	-0.142
<i>child_under5</i>	-0.0268	<i>child5_male</i>	0.0551
	-0.138		-0.142
<i>total_child</i>	0.0552***	<i>marital_statu</i>	0.400***
	-0.00611	<i>s</i>	-0.0133
<i>l_comp</i>	0.0874***	<i>child_sup_fe</i>	-0.121***
	-0.00073	<i>male</i>	-0.0224
<i>d_n_halamj</i>	-0.0613***	<i>ss_fem_2021</i>	-0.0252
	-0.0195		-0.0252
<i>d_n_daatgal</i>	-0.201***	<i>ss_fem_2022</i>	-0.0187
	-0.0116		-0.0211
<i>d_child_sup</i>	-0.00634	<i>Constant</i>	-2.653***
	-0.0194		-0.0697
<i>q_20</i>	0.593***		
	-0.0283		

Тайлбар: 1) Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, ***- 0.001, ** - 0.01, * - 0.05 хувийн зөвшөөрөгдөх түвшинд тухайн регрессийн коэффициент статистикийн хувьд ач холбогдолтойг, харин тэмдэглэгээгүй тохиолдолд ач холбогдолгүйг илэрхийлнэ. 2) Pseudo Rsquare=0.26

Энд *ss_fem_2021*, *ss_fem_2022* нь харгалзан ямар нэг төрлийн халамж авдаг эмэгтэй хөдөлмөр эрхлэлт 2018 оноос өөрчлөгдсөн эсэхийг хэмжих бодлогын нөлөө тооцох хувьсагч юм.

Үнэлгээний давуу тал нь Д.Хишигт судлаач (2019) судалгааны ажилдаа 2007/2008 оны тоон өгөгдөл ашиглан ижил төрлийн судалгаа хийн үр дүнд хүрч байсан бол энэхүү судалгааны ажил нь өгөгдлийг шинэчлэн 2022 оны тоон өгөгдөл ашигласнаараа давуу талтай юм. Түүнчлэн Нээлттэй Нийгэм Форум (2023)-ын судалгаанд халамж, хөдөлмөр эрхлэлтийн хамаарлыг судалсан хэдий ч хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлдөг чухал хувьсагчдыг орхигдуулснаараа дутагдалтай байсныг уг судалгааны ажилд нэмэлтээр тусгасан.

Үнэлгээний сул тал нь олон харилцан хамаарал бүхий дамми хувьсагч тэгшитгэлд оруулсан тул тус хувьсагчид multicollinearity үүсгэн үнэлэгчийн огтлогчийг өөрчилсөн байж болзошгүй гэдгийг анхаарах шаардлагатай.

ҮИ. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар ӨНЭЗС-ны 2018, 2021, 2022 онуудын микро өгөгдөл ашиглан хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсийг DID-Probit загвар ашиглан судалж, бодлогын нөлөөг тооцохыг зорилоо. Судалгааны үр дүнд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад бага байх хандлагатай байгаа ба хүүхдийн мөнгөн тэтгэмж нь эрэгтэйчүүдийнхээс илүүтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулах магадлалтай байна. Эсрэгээрээ цалингийн орлого өсөх, бодит цалин нэмэгдэх нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх статистик ач холбогдолтой байгаа нь түүврийн хувьд орлогын нөлөө давамгайл байх боломжтойг харуулж байна.

Хэрвээ хөдөлмөрийн насны иргэд орлогын ахиу өсөлтөд мэдрэмж сайтай буюу бодит орлого нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэх сонголтыг хийдэг гэж үзвэл татварын хөнгөлөлт ажил хийх хөшүүрэг болох боломжтой юм. Иймд зөвхөн халамж, хөдөлмөр эрхлэлтийн хоорондын нөлөөг судлаад зогсохгүй цаашид халамж, татварын уялдааг судлах нь зүйтэй.

Иймд хөдөлмөр эрхлэлт, халамжийн бодлогын эмпирик судалгаа хийхдээ микро, макро түвшний өгөгдлийг хослуулан судлах шаардлагатай байна хэмээн судлаачдын зүгээс үзлээ. Монгол Улсад татварын хувь хэмжээ хугацааны туршид харьцангуй тогтвортой байж ирсэн тул татварын, халамжийн уялдаа холбоог судлахад хүндрэлтэй байна. Гэсэн хэдий ч иргэдийн бодит орлогын ахиу өөрчлөлтөд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх боломжтойг судлах замаар бодлогын нөлөөг судлан үзэх нь зүйтэй байна.

Халамжийн бодлого хөдөлмөр эрхлэлтийг тэр дундаа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулж байна. Дэлхийн улс орнууд нийгмийн халамжийн үйлчилгээг бэлэн мөнгө олгох болон үйлчилгээ хэлбэрээр хүргэж байна. Манай улсын хувьд 72 төрлийн үйлчилгээнээс олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, рашаан сувиллын хөнгөлөлт, тээврийн зардал, протез, ортопед, хүнс тэжээлийн дэмжлэг зэрэг 11 үйлчилгээг бэлэн бус хэлбэрээр үзүүлж байна. Бусад 61 үйлчилгээ нь иргэний гар дээр бэлэн мөнгөөр олгогддог байна. Ийнхүү бэлэн мөнгө хэлбэрээр үзүүлэх арга хэмжээний тоо олон байгаа нь үйлчилгээ үзүүлэх зардал харьцангуй бага боловч үйлчилгээний дараах үр нөлөө бага байхад нөлөөлдөг ажээ.

Иймд халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хүрээнд одоо нийтлэг хэлбэрээр хэрэгжиж буй халамжийг зорилтот бүлэгт шилжүүлж, хөдөлмөр эрхэлж буй өрхөд гэр

бүлийн нөхцөл байдлаас хамаарсан татварын хөнгөлөлт эдлүүлж, тэдний орлогыг өсгөх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нь оновчтой байна.

Хавсралт

Хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсийн үнэлгээ, Пробит загварын үр дүн

VARIABLES	(1) emp	(2) emp	(3) emp
age	0.148*** (0.00346)	0.148*** (0.00345)	0.143*** (0.00338)
agesq	-0.00182*** (4.41e-05)	-0.00181*** (4.41e-05)	-0.00175*** (4.31e-05)
hhszise	-0.0462*** (0.00570)	-0.0473*** (0.00566)	-0.0619*** (0.00516)
health	-0.222*** (0.0146)	-0.222*** (0.0146)	-0.246*** (0.0145)
education	-0.0302*** (0.00134)	-0.0297*** (0.00134)	-0.0273*** (0.00132)
female	-0.191*** (0.0270)		-0.128*** (0.0198)
child_under5	-0.00277 (0.138)	-0.00379 (0.138)	-0.0268 (0.138)
total_child	0.0520*** (0.00620)	0.0525*** (0.00619)	0.0552*** (0.00611)
l_child_sup	0.105*** (0.0107)	0.110*** (0.0105)	
l_comp	0.0876*** (0.000731)	0.0872*** (0.000730)	0.0874*** (0.000726)
l_n_daatgal	-0.0980*** (0.0123)	-0.0968*** (0.0123)	
l_n_halamj	-0.156*** (0.00797)	-0.155*** (0.00793)	
l_pension	0.0158*** (0.00140)	0.0165*** (0.00139)	
d_n_halamj	2.132*** (0.108)	2.079*** (0.105)	0.0613*** (0.0195)
d_n_daatgal	1.134*** (0.181)	1.102*** (0.181)	-0.201*** (0.0116)
d_child_sup	-1.359*** (0.143)	-1.424*** (0.139)	-0.00634 (0.0194)
q_20	0.0216 (0.0877)	0.597*** (0.0286)	0.593*** (0.0283)
q_40	0.0129 (0.0670)	-0.000928 (0.0280)	-0.0257 (0.0277)
q_60	-0.0234 (0.0751)	-0.0991*** (0.0279)	-0.118*** (0.0277)

q_80	0.101 (0.0804)	-0.0209 (0.0281)	-0.0234 (0.0279)
y2021	0.273*** (0.0309)	0.261*** (0.0290)	0.164*** (0.0264)
y2022	0.275*** (0.0288)	0.258*** (0.0265)	0.188*** (0.0241)
ss_fem_2021	-0.0508 (0.0336)	-0.0337 (0.0251)	-0.0252 (0.0252)
ss_fem_2022	-0.0531* (0.0306)	-0.0317 (0.0209)	-0.0187 (0.0211)
ss_fem_q20	0.522*** (0.0941)		
ss_fem_q40	-0.0478 (0.0762)		
ss_fem_q60	-0.118 (0.0837)		
ss_fem_q80	-0.151* (0.0886)		
ss_male_q20	0.746*** (0.0881)		
ss_male_q40	-0.0511 (0.0680)		
ss_male_q60	-0.0972 (0.0763)		
ss_male_q80	-0.192** (0.0823)		
non_ss_fem_q20	0.119 (0.131)		
non_ss_fem_q40	0.302*** (0.0869)		
non_ss_fem_q60	0.177* (0.0970)		
non_ss_fem_q80	0.246** (0.104)		
child5_female	-0.0296 (0.142)	-0.242* (0.142)	0.00575 (0.142)
child5_male	0.0370 (0.143)	0.0451 (0.143)	0.0551 (0.142)
marriage_status	0.388*** (0.0135)	0.393*** (0.0134)	0.400*** (0.0133)
non_child5_female		-0.205*** (0.0154)	
child_sup_female			-0.121*** (0.0224)

Constant	-2.800*** (0.0769)	-2.744*** (0.0724)	-2.653*** (0.0697)
Observations	90,001	90,001	90,001

t statistics in parentheses

* p<0.05, ** p<0.01, *** p<0.00

VIII. НОМ ЗҮЙ

D.Hoffman, S. (2008). Revising Marshall's Third law: Why does labor's share interact with the elasticity of substitution to decrease the elasticity of labor's demand?

<https://doi.org/10.2139/ssrn.1144053>

International Monetary Fund. (2022). Gendered Taxes: The Interaction of Tax Policy with Gender Equality. 54. <https://doi.org/10.5089/9798400201127.001>

Khishigt Dandarchuluun, H. J. (2019). The Effect of Universal Child Benefit on Female Labor Supply: Case of Mongolia. 11.

McKinsey Global Institute. (2018). The power of parity: Advancing women's equality in Asia Pacific. McKinsey & Company.

Stancanelli, E. G. (2008). Evaluating the impact of the French tax credit on the employment rate of women. 12. <https://doi.org/10.1016/j.jpubeco.2008.02.007>

Азийн хөгжлийн банк. (2020). *Ажиллах хүч дэх эмэгтэй, эрэгтэйчүүдийн оролцоог ижил түвшинд хүргэснээр Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих нь*. Манила: Азийн хөгжлийн банк.

Б.Даваамаа. (2020). Залуу эмэгтэй төгсөгчдийн ажиллах хүчний оролцоо.

Б.Дуламзаяа. (2022). Ковид-19 цар тахлын хөдөлмөрийн зах зээлд үзүүлсэн нөлөө: Монгол улсын жишээ. 24.

Г.Цэвээндолгор. (2022). Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд асран хамгаалах ажлын үзүүлэх нөлөөг хэмжих нь. 11.

Д.Оюунцэцэг. (2013). Нийгмийн халамжийн бодлогын үр дүнгийн судалгаа. 9.

Жендерийн үндэсний хороо. (2022). Жендерийн тэгш байдлын өнөөгийн түвшин.

Нээлтэй нийгэм форум. (2023). Цалин ба халамжийн бодлого иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөөллийн судалгаа. 89.

С.Мөнхчимэг. (2018). Нийгмийн халамжийн хөдөлмөрийн зах зээл, ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөө. 24.

С.Түмэндэлгэр. (2004). Хөдөлмөр эрхлэлт дэх жендерийн ялгааг тайлбарлах зарим онолууд.

Удирдлагын академи. (2020). *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүнгийн шинжилгээ*. Улаанбаатар.